


Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
2026 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
01/1364 дугаар албан бичгийн хавсралт



**"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН 2026 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

(2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хариуцах хэлтэс, нэгж	Хэрэгжилтийн тайлан
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	I-IV улиралд	Олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээллийн тоо	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байна.	Сургалт судалгаа, инновацын хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	2026 оны эхний хагас жилд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээлэл, зурагт хуудас, гарын авлагыг байгууллагын бүх нэгжийн өрөөнүүдэд нийт 5 удаа тараасан бөгөөд "Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10" сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжтой бүхий л хэлбэрээр нийт 35 ажилтанд хүргэн ажилласан. Баримтыг архивд хадгалсан.
		1.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигын эсрэг арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах;	I-IV улиралд	2-оос удаа доошгүй	Авлигын эсрэг арга хэмжээг дэмжиж, хамтран ажилласан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Тайлант хугацаанд байгууллагын онцлогт тохируулан авлигын эсрэг 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газраас авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, төрийн болон албаны нууцыг хамгаалах чиглэлийн хамтарсан сургалтад оролцохоор 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1349 дугаартай албан бичгийг хүргүүлж, 06 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Мөн байгууллагын дотоод арга хэмжээний хүрээнд авлигын эсрэг сурталчилгааг зохион байгуулан хэрэгжүүлсэн.
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10" мэдээллийн самбарыг шинэчлэх.	I-IV улиралд	Шинэчилсэн мэдээллийн тоо	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллийг самбарт тогтмол байршуулж, мэдээллийг шинэчилсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	"Шударга ёс, хөгжил дэвшилд 11-10" мэдээллийн самбарыг 2026 оны I, II улиралд тус бүр 1 удаа шинэчилж Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллийг байршуулсан. Тайлант хугацаанд нийт 2 удаа шинэчлэлт хийгдсэн.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан	2.1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулсан байх;	I-IV улиралд	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	2026 оны I улиралд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигын эсрэг анхан шатны сургалтад байгууллагын удирдлага болон хуулийн ахлах

	хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.2. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран байгууллагын удирдлагуудад чиглэсэн зорилтот сургалтыг зохион байгуулах.	I-IV улиралд	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	мэргэжилтэн, мэргэжилтэн нийт 3 албан хаагч хамрагдсан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран байгууллагын удирдлагуудад чиглэсэн зорилтот сургалтад удирдах ажилтан хамрагдсан. Мөн Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газраас авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчил үүсэх эрсдэлээс сэргийлэх, төрийн болон албаны нууцыг хамгаалах чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг боловсруулан албажуулж, 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1349 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд 06 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх, хүргүүлэх	3.1. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах чиглэлийн хүрээнд холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах.	I-IV улиралд	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Арга хэмжээг хэрэгжүүлж, хариу тайлан, мэдэгдэл хүргүүлсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Холбогдох хэлтэс, нэгжүүд	Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах чиглэлийн шаардлага ирүүлээгүй. Байгууллагын зүгээс холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх дотоод журам, харилцааны механизмыг урьдчилан тогтоож, хариуцсан ажилтныг томилон ажиллуулж байна. Ирэх шаардлага, зөвлөмж бүрийг хугацаанд нь биелүүлэхэд бэлэн байгаа болно.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1. Байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгаж хэвших; 4.2. Албан тушаалтнуудыг мэдээллээр хангах, төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.	I-IV улиралд	Батлагдсан гэрээний тоо	Гэрээнд холбогдох заалтыг тусгасан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Холбогдох хэлтэс, нэгжүүд	Тайлант хугацаанд байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан нийт 12 гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх холбогдох заалтыг тусгаж хэрэгжүүлсэн. Гэрээний стандарт загварт энэхүү заалтыг тогтмол тусгаж байна.
			I-IV улиралд	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Байгууллагын удирдлага болон холбогдох нэгжийн дарга нарт авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулсан. Мөн ISO 37001 — Авлигын эсрэг тогтолцооны хэрэгжүүлэлтийн мэдлэг олгох сургалтад төвийн 2 ажилтныг хамруулсан. ISO 37001 — Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын "Тэргүүлэх аудитор"-ын сургалтад 1 ажилтныг хамруулсан /Хавсралт/.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх	5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	I-IV улиралд	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Алба хаагчид албан үүргээ гүйцэтгэх, шинжээчээр ажиллаж, дүгнэлт гаргах явцад ашиг сонирхлын зөрчил үүсэх, өртөх

	шалтгаан нөхцөлийг арилгуулах	чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.			замаар хүнд суртал чирэгдлийг багасгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна.		эрсдэлээс сэргийлж, шинжээчээр ажиллахаас татгалзсан тохиолдол бүрд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар"-ыг гаргуулах зохион байгуулалтыг хэрэгжүүлж байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/980 дугаартай албан бичгийг хүргэж, тус газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/6199 дугаартай албан бичгээр эрх олгогдсон албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн авсан.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	6.1. Ажлын байрны сул орон тооны зарыг төвийн албан ёсны веб хуудсанд тогтмол байршуулж хэвших;	I-IV улиралд	Байршуулсан зарын тоо	Ажлын байрны сул орон тооны зарыг төвийн албан ёсны веб хуудаст байршуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Тайлант хугацаанд байгууллагын албан ёсны веб хуудсанд ажлын байрны сул орон тооны зарыг нийт 3 удаа байршуулсан бөгөөд зар тус бүрийг хугацаа дуусах хүртэл нийтэд нэвтрэх боломжтой байдлаар байлгаж, иргэд, олон нийтэд мэдээлсэн.
		6.2. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг хуульд заасан хугацаанд албан ёсны цахим хуудсанд байршуулах, иргэд олон нийт танилцах боломжоор хангах.	I-IV улиралд	Мэдээллийн тоо	Арга хэмжээг цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Байгууллагын "Хэрэглэгчийн мэдээлэл оруулах" тайлан үүсгэх цэсэд захирлын А тушаалтай холбогдох мэдээллийг 2026 оны 04 дүгээр сард 98, 05 дугаар сард 67, 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 37, нийт 202 мэдээллийг хугацаанд нь оруулан баталгаажуулсан. Мөн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан мэдээллүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон shilen.gov.mn системд хуульд заасан хугацаанд байршуулан иргэд, олон нийт танилцах боломжоор ханган ажилласан.

Хавсралт

ISO 37001 — Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын "Тэргүүлэх аудитор"-ын сургалтын тухай мэдээлэл



ISO/IEC 37001- Авлигын эсрэг менежментийн тогтолцооны тэргүүлэх аудиторовын сургалт

Монголын стандарт, чанарын хүрээлэнгээс Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын тэргүүлэх аудитор бэлтгэх сургалтыг зохион байгуулах гэж байна.

Сургалтын онцлог

- Энэхүү сургалт нь олон улсын тэргүүлэх аудитор бэлтгэх сургалт тул үндсэн 40 цагийн хичээл англи хэл дээр явагдана.
- Интерактив хандлага буюу багштайгаа чөлөөтэй асуулт, харилт авах байдлаар харилцана.
- Авлигын эсрэг менежментийн чиглэлээр дагнасан мэдлэгтэй чадварлаг, туршлагатай сургагч багшаар заагдана.
- Сургалтын хөтөлбөр нь 100 гаруй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагатай багш нар бэлтгэсэн. Одоогийн салбарын хөгжил, технологийн дагуу шинэчлэгдсэн.
- Сургалтын төгсгөлд BSCIC, EXEMPLAR GLOBAL байгууллагын гэрчилгээ олгох шалгалт явагдана.

Сургалтын дэлгэрэнгүй

- Үргэлжлэх хугацаа: 5 хоног 40 академик цаг
- Үндсэн сургалт: 40 академик цаг 5 хоног, онлайн
- Огноо: 2025 оны 06-р сарын 14,15,16,17,18-ны өдрүүдэд
- Сургалтын цаг: 09:30-16:30
- Сургалтын төлбөр: 2 сая 150 мянган төгрөг /BSCIC & EXEMPLAR GLOBAL/
- *Жич: Сургалтын төлбөрт олон улсын гэрчилгээ авах шалгалтын үнэ орсон байгаа. Суралцагч хоёр удаа шалгалт өгөх эрхтэй.*
- *Суралцагч нь тэргүүлэх аудиторовын олон улсын шалгалтанд тэнцсэн тохиолдолд 5 жилийн хугацаатай гэрчилгээ гардан авах болно.*

Сургалтын ашиг тус суралцагчид

- Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд аудит хийх мэдлэг, ур чадварыг олгох
- Авлигын эсрэг менежментийн тогтолцооны шаардлагуудын үндсэн ойлголтыг бүрэн дүүрэн ойлгох
- Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд

Сургалтын хамрах хүрээ

- Авлигын эсрэг менежментийн тогтолцооны тухай
- Авлигын эсрэг менежментийн тогтолцоо гэж юу вэ?
- Бизнесийн хувьд Авлигын эсрэг менежментийн стандартыг нэвтрүүлсний ач



- аудит хийх багшг удирдан чиглүүлэх, үр дүнтэй гүйцэтгэх чадамжгүйг язэмгдүүлэх
- Интерактив сургалтын ойлголтыг сайжруулах зорилгоор загварчилсан бодит кейс дээр ажиллах
- Сургалтын сэдвүүдийг бодит цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулахад анхаарна.
- Амжилттай төгссөн гэрчилгээ BSCIC, Exemplar global байгууллага баталгаажуулсан.

- холбогдол
- ISO 37001-д заасан нэр томъёо, тодорхойлолт
- ISO 37001-ийн заалт ба зарчим
- Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд хэрхэн үр дүнтэй аудит хийх вэ?
- Аудитын зарчим ба ур чадвар
- Авлигын эсрэг менежментийн стандартын ач холбогдол
- Үл тохирлын тайлал

Сургалтын дагалдах материал

- Сургалтын слайдууд
- Сургалтанд хэрэглэгдэх бодит кейсүүд
- Дасгал ажлын дэвтэр
- Бодит шалгалтын бүтэцтэй адил кейс

Байгууллагад үзүүлэх ашиг тус

- Авлигын эсрэг менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг ойлгосон, ур чадвартай мэргэжилтэнтэй болох.
- Ингэснээр байгууллагадаа Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, дотоод аудит хийх боломж бүрдэх юм.

Холбоо барих:

Утас: 77497878, 89150758

Имэйл: info@msqi.mn

Цахим хуудас: www.msqi.mn